



I-IV/2022

Тархаасан: 2022 оны 5 дугаар сарын 12




Төмөр замын тээврээр зорчигчид өмнөх сараас 73.9 хувиар өслөө

Төмөр замын тээвэр

Төмөр замын тээврээр 2022 оны эхний 4 сард 8.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.4 (22.3%) сая тонноор буурчээ.

ЗУРАГ 1. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРЭЭР ТЭЭСЭН АЧАА, сараар, мянган тонн



Төмөр замын тээврээр тээсэн ачааны бууралтад экспортын ачаа 1.8 (47.1%) сая тонн, дотоод ачаа 313.6 (7.1%) мянган тонноор тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2022 оны 4 дүгээр сард 2.2 сая тонн болж, өмнөх сараас 135.9 (5.9%) мянган тонноор буурсан байна.

Энэхүү бууралтад нүүрс 272.2 (28.0%) мянган тонн, мод, модон материал 9.6 (87.9%) мянган тонноор тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 1. ТӨМӨР ЗАМААР ДОТООД, ГАДААДАД ТЭЭСЭН АЧАА,

бүтээгдэхүүний бүлгээр, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эхний 4 сарын байдлаар


	2020 I-IV	2021 I-IV	2022* I-IV
Бүгд	100.0	100.0	100.0
Уул уурхайн бүтээгдэхүүн	90.4	83.5	84.5
Барилгын материал	3.9	11.4	10.2
Мод, модон материал	0.5	0.3	0.4
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	0.8	1.1	0.8
ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	1.1	1.1	0.5
Хар төмөр (хаягдал, рельс г.м)	1.2	0.8	1.3
Үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	0.1	0.1	0.1
Бусад	2.0	1.7	2.2

Төмөр замаар 2022 оны эхний 4 сард тээсэн ачаанаас өмнөх оны мөн үеэс уул уурхайн бүтээгдэхүүн 1.7 (25.0%) сая тонн, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 64.0 (67.1%) мянган тонн, барилгын материал 316.5 (33.5%) мянган тонн, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн 40.6 (44.4%) мянган тонноор буурч, харин хар төмөр 18.2 (28.0%) мянган тонноор өссөн байна.

Цар тахлын нөхцөл байдлын улмаас өмнөх оны мөн үед төмөр замын зорчигч тээврийн үйл ажиллагааг хязгаарласан байсан бол төмөр замын тээврээр зорчигчид 2022 оны эхний 4 сарын байдлаар 555.6 (давхардсан тоо) мянга болжээ. Төмөр замын тээврээр зорчигчид өсөхөд орон нутгийн зорчигч тээврийн хөдөлгөөнийг нээсэн нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврээр орон нутагт зорчигчид 2022 оны 4 дүгээр сард 211.6 (давхардсан тоо) мянга болж, өмнөх сараас 89.8 (73.9%) мянган хүнээр өссөн байна.

ЗУРАГ 2. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРЭЭР ЗОРЧИГЧИД, сараар, мянган хүн




Төмөр замын тээврийн орлого 2022 оны эхний 4 сард 204.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 53.8 (20.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэхүү бууралтад нефть, нефтийн бүтээгдэхүүн, жонш, жоншны баяжмал, төмрийн хүдрийн тээвэрлэлт буурсан нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврийн орлого 2022 оны 4 дүгээр сард 59.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 4.7 (8.7%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Агаарын тээвэр

Агаарын тээврээр тээсэн ачаа 2022 оны эхний 4 сард 3.9 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 2.8 (3.4 дахин) мянган тонноор өссөн байна.

ЗУРАГ 3. АГААРЫН ТЭЭВРЭЭР ТЭЭСЭН АЧАА, сараар, тонн




Агаарын тээврээр 2022 оны эхний 4 сард дотоодод 5.1 тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 0.9 (14.8%) тонноор буурсан байна.

Мөн олон улсад тээсэн ачаа 3.9 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 2.8 (3.4 дахин) мянган тонноор өссөн байна.

Агаарын тээврээр тээсэн ачаа 2022 оны 4 дүгээр сард 1.2 мянган тонн болж, өмнөх сараас 324.7 (38.6%) тонноор өссөн байна. Энэхүү өсөлтөд олон улсад тээсэн ачаа 325.4 (38.8%) тонноор өссөн нь нөлөөлсөн байна.

ЗУРАГ 4. АГААРЫН ТЭЭВРЭЭР ЗОРЧИГЧИД, сараар, мянган хүн



Агаарын тээврээр зорчигчид 2022 оны эхний 4 сард 181.8 мянга (давхардсан тоогоор) болж, өмнөх оны мөн үеэс 148.6 (5.5 дахин) мянган хүнээр өссөн байна.

Агаарын тээврээр зорчигчид 2022 оны 4 дүгээр сард 51.3 мянга болж, өмнөх сараас 1.8 (3.6%) мянган хүнээр өссөн байна.

Энэхүү өсөлтөд Оюутолгой, Алмата, Истанбул, Сөүл, Токио, Франкфурт, Ханой, Хой Ши Мин чиглэлийн зорчигчид өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр орон нутагт зорчигчид 2022 оны эхний 4 сард 95.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 71.9 (4.1 дахин) мянгаар нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд Оюутолгой чиглэлийн зорчигчид 61.8 мянга, Тавантолгой чиглэлийн зорчигчид 4.1 мянга, Ховд чиглэлийн зорчигчид 3.0 мянга, Өлгий чиглэлийн зорчигчид 2.4 мянган хүнээр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2022 оны эхний 4 сард 86.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 76.7 (8.6 дахин) мянгаар нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд Истанбул чиглэлийн зорчигчид 25.8 мянга, Сөүл чиглэлийн зорчигчид 19.9 мянга, Токио чиглэлийн зорчигчид 4.8 мянга, Анталя чиглэлийн зорчигчид 4.1 мянгаар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2022 оны эхний 4 сард 75.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 34.7 (85.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Агаарын тээврийн орлого 2022 оны 4 дүгээр сард 21.3 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 4.1 (24.0%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Тооцох аргачлал:

Ачаа эргэлт: Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тонн километрээр илэрхийлнэ.

Зорчигч эргэлт: Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.

Шилжүүлсэн тонн километр: Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт нь тээврийн төрөл тус бүрд харилцан адилгүй тооцогддог.

Тээврийн орлого: Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэл тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн буюу ачаа, зорчигч тээвэрлэлт түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм.



Эх үүсвэр:

ҮСХ, тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн сарын мэдээ

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 6 дугаар сарын 10

Эдийн засгийн статистикийн газрын

дарга А.Дэмбэрэл

Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын

статистикч М.Батхишиг

Утас: (976-51)-264797

